| 2107                  | Томилуулт, зочны зардал                                    | 4,500,000.00          | 4,500,000.00   | 8,203,500.00          | 8,203,000.00   |
| 210702                | Дотоод албан томилолт                                      | 4,500,000.00          | 4,500,000.00   | 8,203,500.00          | 8,203,000.00   |
| 2108                  | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй | 1,550,000.00          | 1,549,044.00   | 2,390,400.00          | 2,351,244.00   |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний      | 1,000,000.00          | 999,080.00     | 840,500.00            | 840,500.00     |
| 210803                | Даатгалын үйлчилгээ                                        | 200,000.00            | 200,000.00     | 168,100.00            | 153,750.00     |
| 210804                | Тээврийн хэрэгсэлийн татвар                                | 200,000.00            | 199,964.00     | 241,100.00            | 223,454.00     |
| 210805                | Тээврийн хэрэгсэлийн оюуллого                              | 50,000.00             | 50,000.00      | 60,200.00             | 55,000.00      |
| 210806                | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                            | 00.00                 | 00.00          | 1,000,000.00          | 1,000,000.00   |
| 210807                | Газрын төлбөр                                              | 100,000.00            | 100,000.00     | 80,500.00             | 78,540.00      |
|                       | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                             | 254,316,700.00        | 254,020,379.21 | 295,985,000.00        | 295,353,086.00 |
| 1310                  | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                                    | 249,816,700.00        | 249,030,379.21 | 291,485,000.00        | 290,280,886.00 |
| 131001                | Улсын төсвөөс санхүүжих                                    | 249,816,700.00        | 249,030,379.21 | 291,485,000.00        | 290,280,886.00 |
| 132007                | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих                    |                       |                |                       |                |
| 120004                | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС                      | 4,500,000.00          | 4,990,000.00   | 4,500,000.00          | 5,072,200.00   |
| 1200041               | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                  | 4,500,000.00          | 4,990,000.00   | 4,500,000.00          | 5,072,200.00   |
| 4                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл           | 00.00                 | 1,928,469.57   | 00.00                 | 688,469.57     |
| 5                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл          | 00.00                 | 688,469.57     | 00.00                 | 781,588.57     |
| 61                    | БАЙГУУЛЛАГЫН ТОО                                           | 01                    | 01             | 01                    | 01             |
| 610001                | Төсвийн байгууллага                                        | 01                    | 01             | 01                    | 01             |
| 62                    | АЖИЛЛАГСАДЫН ТОО                                           | 15                    | 15             | 15                    | 15             |
| 620001                | Удирдах ажилтан                                            | 01                    | 01             | 01                    | 01             |
| 620002                | Гүйцэтгэх ажилтан                                          | 14                    | 14             | 14                    | 14             |



## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт                                                                     | Өмнөх он            | Гүйцэтгэл           |
|------------|------------------------------------------------------------------------------|---------------------|---------------------|
|            | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                      |                     |                     |
|            | <b>I НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                                   | <b>2,885,978.00</b> | <b>5,037,500.00</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                         | <b>2,885,978.00</b> | <b>5,037,500.00</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                       | 1,975,978.00        | 5,037,500.00        |
| 2103       | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                             | 00.00               | 1,680,000.00        |
| 210304     | Байрны түрээс                                                                | 00.00               | 1,680,000.00        |
| 2104       | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                      | 200,000.00          | 400,000.00          |
| 210401     | Бичиг хэрэг                                                                  | 200,000.00          | 400,000.00          |
| 2105       | <b>Нормативт зардал</b>                                                      | 400,000.00          | 00.00               |
| 210501     | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                              | 400,000.00          | 00.00               |
| 2106       | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                     | 675,978.00          | 700,000.00          |
| 210604     | Урсгал засвар                                                                | 675,978.00          | 700,000.00          |
| 2107       | <b>Томилолт, зочны зардал</b>                                                | 00.00               | 800,000.00          |
| 210702     | Дотоод албан томилолт                                                        | 00.00               | 800,000.00          |
| 2108       | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>              | 700,000.00          | 00.00               |
| 210801     | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж         | 700,000.00          | 00.00               |
| 2109       | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                       | 0.00                | 1,457,500.00        |
| 210901     | Бараа үйлчилгээний бусад зардал                                              | 00.00               | 1,457,500.00        |
| 213        | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                      | 910,000.00          | 0.00                |
| 2132       | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                                | 910,000.00          | 00.00               |
| 213209     | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                      | 910,000.00          | 00.00               |
|            | <b>II ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                     | <b>2,886,000.00</b> | <b>5,037,500.00</b> |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                           | 2,886,000.00        | 5,037,500.00        |
| 131105     | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,886,000.00        | 5,037,500.00        |
|            | <b>IV НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)</b>                           | <b>0.00</b>         | <b>0.00</b>         |
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                             | 0.00                | 0.00                |
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                            | 0.00                | 0.00                |

## 2.7 Ахмадын сангийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт                                                                     | Өмнөх он            | Гүйцэтгэл         |
|------------|------------------------------------------------------------------------------|---------------------|-------------------|
|            | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                      | 1,928,469.57        | 688,569.57        |
|            | <b>I НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                                   | <b>1,240,000.00</b> | <b>680,000.00</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                         | <b>1,240,000.00</b> | <b>680,000.00</b> |
| 213        | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                      | <b>1,240,000.00</b> | <b>680,000.00</b> |
| 2132       | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                                | 1,240,000.00        | 680,000.00        |
| 213209     | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                      | 1,240,000.00        | 680,000.00        |
|            | <b>II ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                     | <b>-</b>            | <b>773,119.00</b> |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                           | 00.00               | 773,119.00        |
| 131105     | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00               | 773,119.00        |
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                             | 1,928,469.57        | 688,469.57        |
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                            | 688,469.57          | 781,588.57        |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлэх, түүнд үзлэг, үнэлгээ, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах тусгай чиг үүрэг бүхий төрийн тусгай алба бөгөөд Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнд тайлангаа нэгтгүүлдэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын харьяа байгууллага юм.

Шүүхийн шинжилгээний албаны шинжээчдийн баг нь цагдаагийн байгууллагын жижүүрийн шуурхай албаны бүрэлдэхүүнтэй хамт хэргийн газрын үзлэгт оролцон ул мөр, эд мөрийн баримт илрүүлэн бэхжүүлж авах, тэдгээрт анхан шатны шинжилгээ хийж дүгнэлт гаргах, гарын хээ, галт зэвсгийн хонгио ба хошууны сан бүрдүүлэх, хэргийн холбогдолтой гарын хээ, хуурамч бичиг баримт, гарын үсэг, гутлын мөр, малын болон тээврийн хэрэгслийн мөр, шүүх эмнэлгийн гэмтлийн зэрэг тогтоох үзлэг, магадлан шинжилгээ, бүлгийн харьяалал тогтоох, цусан дахь согтолтын зэрэг тогтоох, шүүх нягтлан бодох бүртгэлийн магадалгаа хийх зэрэг анхан шатны шинжилгээг богино хугацаанд хийж шинжээчийн дүгнэлт гаргаж хэрэг бүртгэх мөрдөн байцаах шүүх прокурорын байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 69 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас хэрэгжилт 100 %-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Захирлын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн “Аймгийн шүүхийн шинжилгээний албаны орон тооны дээд хязгаарыг батлах тухай” А/37 дугаар тушаалаар тайлант онд 15 орон тоо батлагдсан бөгөөд үүнээс удирдах албан тушаалтан 1, гүйцэтгэх албан тушаалтан 14 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус алба нь тайлангийн хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль болон бусад хууль тогтоомж, МУ-ын Засгийн газрын тогтоол, мөрийн хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн Сайд, хүрээлэнгийн Захирал, аймгийн Засаг даргаас өгсөн үүрэг чиглэл, албан даалгавар, зөвлөмж, тушаал шийдвэрүүдийг үйл ажиллагаандаа удирдлага болгон хэрэгжүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Шүүх шинжилгээний тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн



өөрчлөлттэй холбоотойгоор Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох баримт бичигт орсон өөрчлөлтийг нэгжүүдэд ирүүлэн мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Дотоод аюулгүй байдал хяналт шалгалтын хэлтсээс Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн дагуу дотоод аудитын үйл ажиллагааг удирдан явуулдаг, дотоод аудитор 1 орон тоотой ажилладаг ба батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу салбар нэгжид 3 жил тутамд хяналт шалгалтыг явуулж үр дүнг бүх нэгжүүдэд мэдээлэн цахимаар ярилцлага хийж удирдлага зохион байгуулалтаар ханган ажилладаг байна.

ШШҮХ-ийн Дотоод аюулгүй байдал хяналт шалгалтын хэлтсээс 2022 онд дотоод аудитын шалгалтыг хийгээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 5 дугаар сарын 29-ний А/87 дугаар тушаалаар батлагдсан шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,751.8 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт       | Эхний<br>үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ |          |
|----------------|-------------------|--------------------|----------|
|                |                   | Эцсийн<br>үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б              | 1                 | 2                  | 3=2-1    |
| Мөнгөн хөрөнгө | 688.5             | 781.6              | 93.1     |
| Урьдчилгаа     | 0.0               | 0.0                | 0.0      |
| Авлага         | 51.2              | 0.0                | -51.2    |
| Бараа материал | 9,542.6           | 9,619.5            | 76.9     |
| Үндсэн хөрөнгө | 71,202.2          | 74,835.2           | 3,633.0  |

|                                              |                 |                 |                |
|----------------------------------------------|-----------------|-----------------|----------------|
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>81,484.5</b> | <b>85,236.3</b> | <b>3,751.8</b> |
| Өр төлбөр                                    | 0.0             | 0.0             | 0.0            |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 81,484.5        | 85,236.3        | 3,751.8        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>81,484.5</b> | <b>85,236.3</b> | <b>3,751.8</b> |

Дээрх хүснэгтээс харахад: Төрийн сан дахь Ахмадын сангийн 100140012503 тоот дансанд 781.6 мянган төгрөгийн үлдэгдлийг мөнгөн хөрөнгийн дансанд тайлагнасан нь өмнөх оны үзүүлэлтээс 93.1 мянган төгрөгөөр өссөн өөрчлөлт гарсан байна.

Оны эхэнд байсан 51.2 мянган төгрөгийн цэвэр бохир усны авлагыг хоорондын тооцоогоор суутгал хийж барагдуулсан байна.

Бараа материалын үлдэгдэл 76.9 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал дансанд эд эсийн шинжилгээ хийхэд шаардлагатай урвалж, бодис болон шүүх эмнэлгийн магадлан шинжилгээний зориулалттай хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийн нөөц бэлтгэсэнтэй холбоотой үүссэн байна.

Үндсэн хөрөнгийн дансанд ТӨБЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны 14 дүгээр тогтоол, ШШҮХ-ийн захирлын 2022 оны 12 дугаар сарын 30-ны А/83 дугаар тушаалаар 20,675.4 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авсан болон хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалан 3,751.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 85,236.3 мянган төгрөг болж 3,751.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 346,279.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 4,500.0 мянган төгрөг, нийт зарлагыг 350,779.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албанаас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 67,951.3 мянган төгрөгөөр бууруулан 2022 оны урсгал зардлын төсвийг 282,827.9 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь дээд шатны төсвийн захирагчид 2022 оны 5 дугаар сарын 18-ны 13п/84 тоотой 1,190.1 мянган төгрөгөөр, 2022 оны 7 дугаар сарын 18-ны 13п/117 тоотой 4,000.0 мянган төгрөгөөр, 2022 оны 8 дугаар сарын 19-ний 13п/134 тоотой 2,500.0 мянган төгрөгөөр тус тус зардал хооронд шилжүүлэн зарцуулах хүсэлт хүргүүлж, өр авлагагүй гарахаар зохицуулалт хийлгэсэн бөгөөд 12 дугаар сард 13,157.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 295,985.0 мянган төгрөгөөр 1 удаа төсөвт тодотгол хийсэн байна.

Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл тухайн байгууллагын төсвийн төсөлд хүргүүлсэн саналд үндэслэдэггүй баталдгаас шалтгаалсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсөв 282,827.9 мянган төгрөгийг 13,157.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг шүүхийн шинжилгээ хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 291,485.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, нийт 295,985.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст улсын төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 1,204.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогын давсан 768.8 мянган төгрөг, нийт 1,972.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.



Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 295,353.1 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлаас 631.9 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

| /мянган төгрөгөөр/ |                                                                               |                  |                  |              |              |
|--------------------|-------------------------------------------------------------------------------|------------------|------------------|--------------|--------------|
| д/д                | Хөтөлбөр, арга хэмжээ                                                         | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл        | Зөрүү        | Биелэлт      |
| 1                  | 70707- Шүүхийн шинжилгээ<br>80101- Үндсэн үйл ажиллагааны зардал              | 295,144.5        | 294,512.6        | 631.9        | 99.8%        |
| 2                  | 70707- Шүүхийн шинжилгээ<br>82311- Шүүхийн шинжилгээний тусгай ажил үйлчилгээ | 840.5            | 840.5            | 0.0          | 100%         |
|                    | <b>дүн</b>                                                                    | <b>295,985.0</b> | <b>295,353.1</b> | <b>631.9</b> | <b>99.8%</b> |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2022 онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогод 5,037.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, өр төлбөр үүсэх магадлалтай байсан 5,037.5 мянган төгрөгийн зардлуудыг санхүүжүүлж ажилласан байна.

**3.5.4 Ахмадын сан**

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь ахмадын сангийн 100140012503 тоот дансыг 2018 онд нээлгэсэн бөгөөд оны эхэнд 688.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Тайлант онд монголын уламжлалт цагаан сар, олон улсын ахмадын өдрөөр 2 удаа ахмад наснуудыг хүлээн авч 680.0 мянган төгрөгөөр хүндэтгэл үзүүлсэн байна.

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын дагуу албаны даргын 2022 оны 12 дугаар сарын 23-ний өдрийн Б/07 тоот тушаалаар цалингийн сангийн хэмнэсэн үлдэгдлээс 773.1 мянган төгрөгийг өөрийн байгууллагын Ахмадын сангийн дансанд шилжүүлэн, мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр 781.6 мянган төгрөгийг тайлагнасан байна.

Ахмадын сангийн орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт нэг хөтөлбөрийн хоёр арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

**Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт**

| /мянган төгрөгөөр/ |                            |                           |                                |                            |                 |            |
|--------------------|----------------------------|---------------------------|--------------------------------|----------------------------|-----------------|------------|
| №                  | Хөтөлбөр                   | Хэрэгжих хугацаа          | Хүрэх үр дүн                   | Хэрэгжилтийн явц           | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
| 1                  | 70707<br>Шүүхийн шинжилгээ | 2022.01.01-<br>2022.12.31 | Шүүхийн шинжилгээг хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт 100% | 295,985.0       | 295,353.1  |

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 631.9 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, дутуу зарцуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12п/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн 2022 оны нийт зарлага 291,485.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 4,372.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,279.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага авч хэрэгжүүлсэн ажлын тайланг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт хавсаргаж, ирүүлсэн. Үүнд: Тус байгууллагын 2022 оны шаардлагатай гэж төсөвлөсөн 350,779.2 мянган төгрөгийн төсвийг 15.6 хувиар бууруулан баталсан ба Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллаж нийт 631.9 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсөв бууруулснаас шалтгаалан шүүхийн шинжилгээний алба хаагчдад олгох ёстой хортой нөхцөлийн 1,815.0 мянган төгрөгийг / 1 алба хаагчийн өдөр тутмын хор саармагжуулах зардал 625 төгрөг / 2022 онд олгоогүй байна. Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны төлбөртэй үйлчилгээний нэмэлт орлогод 5,037.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн байгууллагын хэвийн ажиллагааг хангахын тулд грашийн түрээсийн төлбөр, дуудлагаар хөдөө орон нутагт томилолтоор ажилласан алба хаагчдын томилолтын зардлын өр үүсгэхгүйгээр барагдуулсан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 13, зарлагын 1 мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 1 шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 3 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |         | Биелэлт |         |      |
|-----------------|------------------------|---------|---------|---------|------|
|                 | Тоо                    | Дүн     | Тоо     | Дүн     | Хувь |
| Акт             |                        |         |         |         |      |
| Албан шаардлага | 1                      | 3,476.2 | 1       | 3,476.2 | 100  |
| Зөвлөмж         | 1                      | 0.0     | 1       | 0.0     | 100  |
| Нийт дүн        | 2                      | 3,476.2 | 2       | 3,476.2 | 100  |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 3,652.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1,972.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,680.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд: Төсвийн гүйцэтгэлийн тайланд татан төвлөрүүлсэн 1,972.9 мянган төгрөгөөр тохируулга хийгээгүй байсныг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад залруулсан.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. *Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал*

##### 1.1. Илрүүлэлт:

Түрээсийн гэрээний дагуу 1,680.0 мянган төгрөгийн өглөгийг тухай бүр үүсгэж, өглөгийн мэдээнд тусгаагүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” заалтуудтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Өглөгийг тухай бүр бүртгэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга                                                                                                         | Нийт алдаа |         | Мэдээллийг тусгахгүй орхигдуул-сан |     | Буруу тусган илэрхийлсэн |         | мянган төгрөгөөр<br>Үүнээс: |         |              |     | Зөвлөмж |     |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|---------|------------------------------------|-----|--------------------------|---------|-----------------------------|---------|--------------|-----|---------|-----|
|                                                                                                                           |            |         |                                    |     |                          |         | залруулсан                  |         | залруулаагүй |     |         |     |
|                                                                                                                           | тоо        | дүн     | тоо                                | дүн | тоо                      | дүн     | тоо                         | дүн     | тоо          | дүн | тоо     | дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд татан төвлөрүүлсэн 1,972.9 мянган төгрөгөөр тохируулга хийгээгүй алдаатай тайлагнасан байна. | 1          | 1,972.9 |                                    |     | 1                        | 1,972.9 | 1                           | 1,972.9 |              |     |         |     |
|                                                                                                                           |            |         |                                    |     |                          |         |                             |         |              |     |         |     |
| Дүн                                                                                                                       | 1          | 1,972.9 | 0                                  | 0.0 | 1                        | 1,972.9 | 1                           | 1,972.9 | 0            | 0.0 | 0       | 0.0 |

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Алдааны товч утга                                                                                                     | Нийт зөрчил |         | мянган төгрөгөөр<br>Үүнээс: |     |                 |     |         |         |                                      |     |                                                |     |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|---------|-----------------------------|-----|-----------------|-----|---------|---------|--------------------------------------|-----|------------------------------------------------|-----|
|                                                                                                                       |             |         | Төлбөрийн акт               |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |         | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|                                                                                                                       | тоо         | дүн     |                             |     |                 |     |         |         |                                      |     |                                                |     |
| Түрээсийн гэрээний дагуу 1,680.0 мянган төгрөгийн өглөгийг тухай бүр үүсгэж, өглөгийн мэдээнд тусгаагүй зөрчил байна. | 1           | 1,680.0 |                             |     |                 |     | 1       | 1,680.0 |                                      |     |                                                |     |
| Дүн                                                                                                                   | 1           | 1,680.0 | 0                           | 0.0 | 0               | 0.0 | 1       | 1,680.0 | 0                                    | 0.0 | 0                                              | 0.0 |

### 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| мянган төгрөгөөр                                         |             |     |               |     |                 |     |         |     |  |
|----------------------------------------------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--|
| Зөрчлийн товч утга                                       | Нийт зөрчил |     | Үүнээс:       |     |                 |     |         |     |  |
|                                                          |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |  |
|                                                          | тоо         | дүн | тоо           | дүн | тоо             | дүн | тоо     | дүн |  |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |     |               |     |                 |     |         |     |  |
|                                                          |             |     |               |     |                 |     |         |     |  |
| Дүн                                                      |             |     |               |     |                 |     |         |     |  |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |     |               |     |                 |     |         |     |  |
|                                                          |             |     |               |     |                 |     |         |     |  |
| Дүн                                                      |             |     |               |     |                 |     |         |     |  |
| Нийт дүн                                                 | 0           | 0   | 0             | 0   | 0               | 0   | 0       | 0   |  |